



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 488

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасахзөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.5, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2018 оны 02-07-118/953 дугаар дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 22,860,000.00 (хорин хоёр сая найман зуун жаран мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Д.Нарантуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002381

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн
 88 дугаар тогтоолын хавсралт



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр /байршил/	Ашиглал- тад орсон огноо	Нийт талбай (м.кв)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уурын зуухны барилга, /Баянзүрх дүүрэг, 3-р хороо, тус төвийн хашаанд/	1959.02.20	180	22,860,000.00	22,860,000.00	-
	Дүн	-	180	22,860,000.00 (хорин хоёр сая найман зуун жаран мянган)	22,860,000.00 (хорин хоёр сая найман зуун жаран мянган)	-